



60

**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/26

Модот

**Сонсох ажиллагаа явуулах ажлын  
хэсэг томилох тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сургуулийн орчинд гарсан багш, сурагч, эцэг эхэд холбогдох асуудлаар холбогдох этгээдүүдийн Сонсох ажиллагаа зохион явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ж.Мандах  
Нарийн бичиг: О.Жавзмаа  
Гишүүн: Д.Ариунаа

Ёс зүйн дэд хорооны дарга  
Архив, бичиг хэргийн ажилтан  
Сургалтын менежер

2.Сонсох ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 15 цагт багш хөгжлийн өрөөнд явуулах.

3.Сонсох ажиллагаанд холбогдох багш, сурагч, түүний эцэг эх, хариуцсан багшийг оролцуулах.

4.Сонсох ажиллагааны ажлын хэсэг нууцыг чандлан хадгалж Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлах.

5.Сонсох ажиллагааны тэмдэглэл үйлдэж, дүнг сургуулийн захиргаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Д.ОТГОНДУЛАМ

